МОНГОЛ УЛС
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2017 оны 05 сарын 10 өдөр    Дугаар А/152    Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/36 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутагт хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааны чанар хүртээмж, нөхцөл байдалд хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Ганзориг /ГБХЗХГ-ын дарга/
Гишүүд: Б.Хандмаа /Аймгийн ЗДТГ-ын Боловсрол, Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн/
Э.Бямбасүрэн /МХГ-ын Эрүүл ахуй халдвар хамгааллын улсын байцаагч/
Л.Оюунбаяр /БСУГ-ын Боловсрол, соёлын албаны дарга/
Нарийн бичгийн дарга: Х.Мөнхсаруул / ГБХЗХГ-ын ХШҮ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн/

Хоёр. Хяналт шалгалт зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

Гурав. Хяналт шалгалт зохион байгуулсан ажлын тайлан, зөвлөмжийг 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ    Ж.МӨНХЧУЛУУН

023800454

Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын ...10..-ны өдрийн А/152 дугаар захирамжийн хавсралт

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

**ЗОРИЛГО:** Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, нийтлэг шаардлага MNS: 6540:2015 стандарт болон түүнтэй холбогдон гарсан дүрэм, журам, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн №А/36 тоот тушаалын хэрэгжилтийг хангах, орон нутагт үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээний чанар, хүртээмж, нөхцөл байдал, үйл ажиллагаанд нөхцөл байдлын үнэлгээ хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөн тусалж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангахад оршино.

**ХАМРАХ ХҮРЭЭ:** Аймгийн хэмжээнд хүүхэд харах үйлчилгээ үзүүлж буй эрх бүхий байгууллагаас хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авч санхүүжигдэж байгаа иргэн хамаарна.

**ХУГАЦАА:** 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр 10:00 цаг

**ҮНДСЭН ЧИГЛЭЛ:**

- Гэр бүл, хүүхдийн салбарт авч хэрэгжүүлж буй Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөөтэй танилцах, хэрэгжүүлэх явцад гарч буй ололттой болон хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, дүгнэлт зөвлөмж өгөх
- Орон нутагт тулгарч буй хүндрэл бэрхшээлийг даван туулах арга замыг бий болгоход мэргэжлийн зөвлөмж өгөх.
- Хүүхэд харах үйлчилгээнд хамрагддаг хүүхдүүдийн ирцийг тогтмол бүртгэж, нэгдсэн мэдээллийн санг бий болгох
- Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАГААС ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛ:**

- Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS: 6540:2015 стандартын хэрэгжилт
- Хүүхдийн хоол, хүнсний эрүүл ахуй
- Үйлчилгээний чанар, хүртээмж
- 2017 оны 01 дүгээр сард зохион байгуулсан хяналт шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

- Хүүхэд харах үйлчилгээний санхүүгийн анхан шатны баримт, зарцуулалт
- Удирдамжийн хавсралт маягтуудын дагуу хяналт шалгалтыг явуулах

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮР ДҮН:** Хүүхэд харах үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан нөхцөл байдлын үнэлгээг холбогдох хүснэгтийн дагуу хийж, тайлагнана. Мөн агуулагад дурдагдаагүй орчин нөхцөлийг онцлон дүгнэж шаардлагатай бол дүгнэлт, тэмдэглэл хэсэгт тодорхой бичнэ.